

**МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ  
ХООРОНДЫН “МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БОЛОН ЛОГИСТИКИЙГ  
САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Засгийн газарт хүргүүлсэн уг төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтэд зээлийн хөтөлбөрийн төслийг сайжруулах талаар өгсөн 9 чиглэлийг төсөлд тусгасан эсэх, зөвшилцөх төсөлд 311 км замын засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэхээр байсныг 361 км болгож өөрчилснийг тодруулан асууж, төслөөс “эмэгтэй малчдад платформд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжих, сургах” гэснийг хасах талаар ажлын хэсэгт анхааруулсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар 2024 оны улсын төсвийг хэлэлцэхэд Улаанбаатар-Даланзадгад чиглэлийн замын их засварыг Дэлхийн банкны 100 сая ам.долларын зээлийн хүрээнд хийхээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас мэдэгдэж байсан боловч энэ төсөлд тусгагдаагүй байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хэлэлцээрийн төслийн өрийн дээд хязгаарт багтсан байдал, ач холбогдлыг харгалзан дэмжиж байгаагаа илэрхийлээд, урьд нь авч байсан гадны зээлийн талаарх асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар зөвшилцөх үед Засгийн газарт тодорхой үүрэг, чиглэл өгдөг байсан боловч энэ удаагийнх шиг төслөө сайжруулж, өөрчилж ирдэг нь ховор байсныг дурдаад, цаашид төслийг эцэслэн батлахаас өмнө Байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг сонсдог байх нь зүйтэй бөгөөд зөв хандлага, том ахиц гарч байгааг онцлон тэмдэглэсэн болно.

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЭНХ-АМГАЛАН**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн өрдөн, Улаанбаатар  
хот

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН  
БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг